

НОМЫН САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл.

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Политехник коллежийн номын сангийн үйл ажиллагааг мэдээллийн болон уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн хангамжийг сайжруулахтай холбоотой асуудлаар дэмжлэг туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх үүрэг бүхий номын сангийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Номын сангийн зөвлөл нь төв, орон нутгийн нийтийн номын сан, бүх шатны сургуулийн дэргэд ажиллах орон тооны бус нэгж юм.
- 1.3. Энэхүү нийтлэг журамд нийцүүлэн тухайн байгууллагын ажлын онцлогийг харгалзан ерөнхий менежер “Номын сангийн зөвлөл”-ийн ажиллах журмыг тогтооно.
- 1.4. Номын сангийн зөвлөл нь:
 - 1.4.1. Номын санг шинэчлэх хэтийн болон жилийн төлөвлөгөөнд санал оруулах;
 - 1.4.2. Номын сангийн номын баяжилт, ном бүрдүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийх;
- 1.4.3. Номын сангийн уншлага үйлчилгээний ажлын чанарыг сайжруулах, уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном хэвлэлээр баяжилт хийх санал оруулах;
- 1.4.4. Мэдээллийн хангамжийн хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон нийтийн санал, хүсэлтийг уламжлах;
- 1.4.5. Номын сангийн үйлчилгээнд шинэ техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, материаллаг баазыг сайжруулах талаар санал, төсөл оруулах;
- 1.4.6. Номын хангамж хүртээмж, уншлага - үйлчилгээний талаарх судалгааны дүнг хэлэлцэнэ.

Хоёр. Зөвлөлийн ажлын зохион байгуулалт

- 2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгууллагын ерөнхий менежер томилно.
- 2.2. Зөвлөл нь төвийн болон орон нутгийн захиргаа, боловсрол, соёл, олон нийтийн байгууллага, уншигчдын төлөөлөл бүхий 7-9 гишүүнтэй байна.
- 2.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг Зөвлөлийн дарга удирдана.
- 2.4. Зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүйгээр хуралдааныг зарлан хуралдуулна.
- 2.5. Зөвлөлийн гишүүдийн 75-аас доошгүй хувийн ирцтэй тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 2.6. Хуралдаанд хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, хуралдаанаас зөвлөмж гаргана.
- 2.7. Зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүд хэлэлцэж байгаа асуудлын талаар санал гаргана. Хуралдааны явцад гишүүд тодорхой асуудлаар санал зөрвөл санал хураах замаар шийдвэрлэнэ.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, тайлагналт

- 3.1. Зөвлөл нь номын сангийн уншлага үйлчилгээ, мэдээллийн хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх, номын баяжилтыг сайжруулахад олон нийтийн санал, дэмжлэгийг авах, номын сангийн хөгжлийг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ.
- 3.2. Зөвлөл нь номын сангийн үйл ажиллагаа, уншлага үйлчилгээ, номын бүрдүүлэлт зэрэг асуудлаар үйлчлүүлэгч байгууллага болон уншигч олон нийтийн санал хүсэлтийг судлах, номын сангийн төсвийн зарцуулалтад дүн шинжилгээ хийх, зөвлөмж өгөх зэрэг үйл ажиллагаа явуулна.
- 3.3. Зөвлөл нь үйл ажиллагаагаа жил бүрийн дөрөв улиралд багтаан тухайн байгууллагын ерөнхий менежер, хамт олны өмнө тайлагнана.